# МОНГОЛ УЛСЫН
# ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 12-р сарын 2 ны өдөр　　　　Дугаар 264　　　　Улаанбаатар хот

**Магистрантурт суралцуулах тухай**

**Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцагчдыг сонгон шалгаруулах , санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах ажлыг хариуцсан комиссын 1999 оны 7 дугаар сарын 8-ны хурлын тэмдэглэл , Захиалагч яам , газруудын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ :**

1. 1999 - 2000 оны хичээлийн жилээс эхлэн **Ганзоригийн Тогтохбаатар, Гомбын Энхтүвшин** нарыг банк, санхүүгийн менежмент, **Дамдинсүрэнгийн Сүрэнхорыг** гадаад худалдааны, **Гүндэнбалын Цолмонг** англи хэлний багшийн , **Сангажавын Баярмааг** клиник фармакологийн мэргэжлээр АНУ-ын Колородагийн их сургуулийн магистрантурт тус бүр 2 жилийн хугацаатай суралцуулсугай .

2. АНУ-ын Колородагийн их сургуулийн магистрантурт анагаахын мэргэжлээр суралцаж буй **Чулуундоржийн Оюунцэцэгийн** суралцах хугацааг сургуулийн нь саналыг үндэслэн нэг семестр буюу 2000 оны 9 дугаар сарын 1 хүртэл сунгасугай .

3. Гэгээрлийн сайдын 1999 оны 113 дугаар тушаалаар ХБНГУ-д тус улсын эрдэм солилцооны албатай байгуулсан гэрээний дагуу Гетёгийн хэлний институтэд бэлтгэл хийсэн **Доцдовын Долгорсүрэн, Авирмэдийн Түвшинжаргал, Рагчаагийн Баяржавхлан** нарыг үргэлжлүүлэн Дармштатын технологийн их сургуулийн магистрантурт 2 жилийн хугацаатай суралцуулсугай .

4. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан „ Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам „-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулан холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан / Б.Ганбат/ -д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар / Д.Мөнхжаргал/-д тус тус даалгасугай .

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гэгээрлийн сайдын 1999 оны 113 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай .

**САЙД　　　　А.БАТТӨР**